



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 01 сарын 25 өдөр

Дугаар A/110

Мандатговь

**Албан тушаалын тодорхойлолт
шинэчлэн батлах тухай**

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2019 оны 275 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 386 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

1. Захиргаа, хүний нөөц хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр,
2. Хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн /хүүхдийн эрхийн улсын байцаагч/-ын албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар,
3. Гэр бүлийн хөгжил хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар,
4. Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр,
5. Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар,
6. Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар,
7. Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар,
8. Хууль эрх зүй, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар,
9. Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр

Хоёр. Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

Гурав. Албан тушаалын тодорхойлолтыг албажуулан, нэгдсэн санд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа хүний, нөөц хариуцсан ахлах мэргэжилтэн /Р.Мөнхбат/-д даалгасугай.

ДАРГА



ГАНЗОРИГ

491190019